



Улаанбаатар

 П. ОЛЮХ

Огноо

№ 19/10/002.

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 49-р зүйл, 2019 оны 10-р сарын 29-ний өдөр хуралдсан ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компанийн хувьцаа эзэмшигч “БиДиСек ҮЦК” ХК-иас өөрийн эзэмшлийн 2,095,891 ширхэг хувьцааг компанид эргүүлэн худалдах санал ирүүлснийг хүлээн авч, компанийн санхүүгийн боломж бүрдсэн үед шийдвэрлэх, бусад хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг мөн хамгаалан ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Амартүвшин/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Т. ОЮУНБОЛД

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮНИЙГ ТҮР ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5, 77.6 дахь заалтууд, 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100% -ийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдон ажиллаж байсан Мэнд овогтой Төвшингийн хувийн хүсэлтийг харгалзан үзэж ТУЗ-ийн ердийн гишүүнээс чөлөөлсүгэй.
2. М.Төвшинийг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлсөнтэй холбогдуулан нөхөн сонгууль хүртэл Батчулуун овогтой Батпүрэвийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилсугай.
3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг шинээр томилогдсон гишүүн Б.Батпүрэвт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Д. ОЮУНБОЛД

Огноо 2019.10.29

№19/10/004

Улаанбаатар

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
БУС ХУРАЛ ХУРАЛДУУЛАХТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйл, 76.1.2 дахь заалтууд, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Фронттиер лэнд групп" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 12-р сарын 09-ний өдрийн 15.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойрог, Пума Импераил зочид буудлын 2-р давхарт байрлах хурлын бага хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 11-р сарын 18-ний өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн үйл ажиллагааны чиглэл, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
 2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлах
 3. Их хэмжээний болон Сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах
 4. Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авах тухай
 5. Шаардах эрх хэрэгжүүлэх тухай
 6. Бусад.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2019 оны 11-р сарын 02-ны өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2019 оны 11-р сарын 17-нд уг зарыг давтан, 2019 оны 11-р сарын 06-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2019 оны 12-р сарын 09-ний өдрийн 10.00 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.

7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2019 оны 11-р сарын 05 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /О.Амартүвшин/-т даалгасугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Гүйцэтгэх Захирал О.Амартүвшин, гишүүнээр У.Анар, Тооллогын комиссийн даргаар С.Шижиртуяа, гишүүнээр М.Батбаатар нарыг тус тус томилсугай.
10. “Фронтинер лэнд групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ОЮУНБОЛД